



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллах тухай.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2019 оны А/88 дугаар захирамж, Хан-Уул дүүргийн засаг даргын А/98 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль” 2019 оны 04 сарын 24, 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулагдахтай холбогдуулан 2019 оны 04 сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.


2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд бэлэн байдлыг хангаж, эмч эмнэлгийн албан хаагчдын амралт чөлөөг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, идэвх санаачлагатай ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгч нарт даалгасугай.

3. Гамшгийн сургуулийн бэлтгэл ажлыг хангах, эрчимжүүлэх зорилгоор тус эрүүл мэндийн төвийн удирдах ажилтан, нийт эмч, сувилагч, нярав, асрагч, жолооч слесерь, цахилгаанчин, үйлчлэгч бусад албан хаагчид холбоо барих утасны дугаарыг холбогдох тасаг нэгжийн дарга эрхлэгч нарт тэмдэглүүлэн тохиолдож болзошгүй гамшиг, онцгой байдлын үед байнга нээлттэй байлгахыг үүрэг болгосугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед дур мэдэн ажил таслах, хуваарьт ажлаа өөрчлөх, гар утсаа аваагүй эсвэл хаалттай тохиолдолд “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн дагуу сахилгын шийтгэл оногдуулахыг анхаарсугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

00170 70 0285